



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААНД НОГДОХ НОГДОЛ АШГИЙГ БҮРЭН
ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН НЭГЖ ХУВЬЦААНД
ОЛГОСОН НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: НАГ-2026/12-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2026 он

Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор **Б.Баттуяа**

Утас: 260949, Цахим хаяг: battuyab@audit.gov.mn

Арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан
менежер **Д.Баттулга**

Утас: 329875, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Аудитын менежер **П.Ундармаа**

Утас: 261839, Цахим хаяг: undarmaap@audit.gov.mn

Ахлах аудитор **Ш.Наранбаатар**

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор **Н.Хандмаа**

Цахим хаяг: khandmaan@audit.gov.mn

Аудитор **Н.Түмэнцэцэг**

Цахим хаяг: tumentsetsegn@audit.gov.mn

Аудитор **М.Минжин**

Цахим хаяг: minjinm@audit.gov.mn

Аудитор **М.Отгонбаяр**

Цахим хаяг: otgonbayarm@audit.gov.mn

Өгөгдлийн шинжилгээний аудитор **Б.Эрдэнэхүү**

Цахим хаяг: erdenekhuub@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэгж хувьцаанд олгосон ногдол ашгийн хуваарилалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д тус тус хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Б.Энхбаяр), “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Даваадалай), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Чагнаадорж), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Тавинжил) нарт тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор (Ч.Цэвэгдорж)-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2026\EA-In A Tushaal\0707 NAIG-2.Docx

1526010310

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026
оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн А/86
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэгж хувьцаанд олгосон ногдол ашгийн хуваарилалт, хууль тогтоомжийн хэрэгжилт

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	5
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
БҮЛЭГ 1. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.7	7
Төрийн өмчид ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхгүйгээр өр, авлагад суутган тооцох шийдвэр гаргасан байна.	7
Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчээс ирүүлж буй удирдамжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тогтоож байна.....	8
БҮЛЭГ 2. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК НЬ ТӨРД НОГДОХ НОГДОЛ АШГИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЗАРДЛЫГ ОНОВЧГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.....	14
Хамаарал бүхий компаниудад олгосон санхүүжилт компанийн ашигт ажиллагаанд шууд нөлөөлөхгүй ч ирээдүйд эрсдэл бий болох нөхцөл бүрдэж байна.....	14
“Тавантолгой түлш” ХХК-д олгосон санхүүжилтийн эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.....	15
“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг “Монголын төмөр зам” ХХК-д нэгтгэсэнтэй холбоотойгоор оруулсан хөрөнгө оруулалтыг зээлийн гэрээнд шилжүүлсэн байна.	15
Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй төсөлд санхүүжилт олгож байна.	16
Менежментийн үйлчилгээний төлбөр нь компанийн цаашдын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.	18
“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.	20
Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот арга хэмжээнд чиглээгүй, хандив, тусламж болон төсвийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.	22
Санхүүгийн тайлангийн шинжилгээнд үндэслэлгүй нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг тогтоож байгаа нь компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэхээр байна.....	24
Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг бүрэн төвлөрүүлээгүй байна.....	28
ДҮГНЭЛТ.....	30
ЗӨВЛӨМЖ	31
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	32
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	32

Товчилсон үгийн тайлбар

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХЯ	Батлан хамгаалах яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл
ҮЦЗЗтХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХК	Хувьцаат компани
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭУБтХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрх	8
Хүснэгт 2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэл/2025.12.31-ний байдлаар/	10
Хүснэгт 3. Хувьцаа эзэмшүүлэхээс өмнө Монгол Улсын харьяатаас гарсан, нас барсан иргэд	11
Хүснэгт 4. Хүчингүй регистрийн дугаартай болон бүртгэл давхардсан иргэдийн бүртгэл	11
Хүснэгт 5. Охин болон хараат компаниудад олгосон санхүүжилт, тэрбум төгрөгөөр	15
Хүснэгт 6. Томоохон төслүүдийн товч мэдээлэл /2025.12.31-ний байдлаар/	18
Хүснэгт 7. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлого, зардлын дүн, тэрбум төгрөгөөр	19
Хүснэгт 8. Гэрээний төрөл, үнийн дүнгийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр	19
Хүснэгт 9. Борлуулалтын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	20
Хүснэгт 10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	21
Хүснэгт 11. Нийгмийн хариуцлагын 2023-2025 оны зардал, сая төгрөгөөр	23
Хүснэгт 12. “Хамтын ажиллагааны гэрээ”-ний хүрээнд олгосон санхүүжилт, сая төгрөгөөр	24
Хүснэгт 13. “Сая тонн – сая мод” хөтөлбөрийн ерөнхий бүсчилсэн төлөвлөгөөний хэрэгжилт	24
Хүснэгт 14. Тайлант үеийн зардлын төрлөөр борлуулалтын орлогод эзлэх хувь	25
Хүснэгт 15. Ногдол ашиг хуваарилсны дараах төлбөрийн чадварын шинжилгээ он тус бүрээр	26
Хүснэгт 16. Ногдол ашиг хуваарилалтын нэгтгэл, дүн, сая төгрөгөөр /2026.05.22/	27
Хүснэгт 17. Хувьцаа эзэмшигчдийн тараагдаагүй ногдол ашгийн бүртгэлийн төлөв	27
Хүснэгт 18. Хувьцаа анх эзэмшүүлэхээс өмнө нас барсан болон харьяатаас гарсан иргэдийн мэдээлэл, ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр	27
Хүснэгт 19. Ногдол ашгийг хүчингүй регистрийн дугаараар хуваарилсан хувьцаа эзэмшигчийн тоо, ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр	28
Хүснэгт 20. Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашиг, тэрбум төгрөгөөр	29

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1. Ногдол ашиг олгохтой холбоотойгоор гарсан УИХ болон ЗГ-ын тогтоолууд	8
Дүрслэл 2. Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ирүүлсэн ногдол ашиг олгохтой холбоотой удирдамжийн нэгтгэл	10
Дүрслэл 3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой УИХ, ЗГ-ын шийдвэрүүд	13
Дүрслэл 4. Нээлттэй хувьцаат компани болгох хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанд нээж, арилжаалах хүртэлх хууль, эрх зүйн шаардлага	14
Дүрслэл 5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн охин болон хараат компанийн хувь эзэмшил, шийдвэр	15
Дүрслэл 6. “Зүүнбаян төмөр зам” ХХК-д олгосон санхүүжилт, тэрбум төгрөгөөр	17
Дүрслэл 7. Хөрөнгө оруулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл, сая төгрөгөөр	17
Дүрслэл 8. Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг	25
Дүрслэл 9. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого болон цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр	25
Дүрслэл 10. Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг, зарласан ногдол ашиг, төгрөгөөр	25
Дүрслэл 11. Иргэд, аж ахуй нэгжид хуваарилсан ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр	26
Дүрслэл 12. Ирээдүйн өв сан болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн зохицуулалт	29

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 оны аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилго:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэгж хувьцаанд олгосон ногдол ашгийн хуваарилалт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг хуваарилах хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийг хууль тогтоомжийн дагуу бодитой тооцож олгосон эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудын 2019-2025 оны ногдол ашиг, түүнийг хуваарилахтай холбоотой баримт материалыг хамруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Иргэний хууль;
- Компанийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай;
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль;
- ТБОНӨХБАҮХАТухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолууд;

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга арга зүйгээр хангаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Ундармаа хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Наранбаатар, аудитор Н.Хандмаа, Н.Түмэнцэцэг, М.Минжин, М.Отгонбаяр, өгөгдлийн шинжилгээний аудитор Б.Эрдэнэхүү нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор Тавантолгойн ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан байна.

Улсын Их хурлын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоолоор дараах асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх:
- Монгол Улсын нийт иргэнд эхний ээлжинд хувьцааны 20 хувийг адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх;
- хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө Улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;
- хувьцааны 20 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;

Дээрх тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг үүсгэн байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 367 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийг төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байхаар баталсан байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.6.11-д Монгол Улсын иргэдэд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хүртээнэ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нүүрсний ордын нийт талбайн 95.4 хувь буюу 68,471.4 га талбайд 8 тусгай зөвшөөрөл эзэмшин, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа хийж байна.

Тус компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг тооцож, иргэн бүрд 96,480 төгрөг олгосон бол 2020-2021 онд ногдол ашиг хуваарилаагүй, 2022 онд 108.7 төгрөг, 2023 онд 266 төгрөг, 2024 онд 326.5 төгрөгийг нэгж хувьцааны ногдол ашигт тооцож хуваарилжээ.

Харин 2025 онд 1.1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр 2025 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 65.55 төгрөгөөр тооцон, 2026 оны 2 дугаар улиралд 488 аж ахуйн нэгжид 416.8 сая төгрөг, 3408021 иргэнд 187,469.3 сая төгрөг, нийт 187,886.1 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019 оноос хойш нийт 10,020.2 тэрбум төгрөгийг ногдол ашигт хуваарилснаас төрийн эзэмшлийн хувьцаанд нийт 7,643.4 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжид 5.4 тэрбум төгрөг, иргэдэд 2,371.4 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

БҮЛЭГ 1. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.

Төрийн өмчид ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхгүйгээр өр, авлагад суутган тооцох шийдвэр гаргасан байна.

1.1 Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрхийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлээр зохицуулсан байна. Тухайлбал;

Хүснэгт 1. Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрх

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	
8 дугаар зүйл. Төрийн өмчийн талаарх Улсын Их Хурлын бүрэн эрх	9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрх
1/ Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх; 2/ төрийн өмчийн улсын нэгдсэн тооллогын дүнгийн тухай Засгийн газрын тайланг хэлэлцэх, төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох; 5/ төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах; 7/ хуульд заасан бусад бүрэн эрх.	1/ төрийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах; 2/ төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох; 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах; 10/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны төрийн өмчид ногдох хэсгийг хувьчлах хөтөлбөр, банкин дахь төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх журмыг Монгол банктай зөвшилцөн батална; 11/ хуульд заасан бусад бүрэн эрх.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

1.2 Улсын Их Хурал, Засгийн газар нь бүрэн эрхийнхээ хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх, ногдол ашиг тараахтай холбоотойгоор 2019-2026 оны хооронд нийт 24 тогтоол, шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

Дүрслэл 1. Ногдол ашиг олгохтой холбоотойгоор гарсан УИХ болон ЗГ-ын тогтоолууд

УИХ, ЗГ-ын тогтоолууд			
№	Байгууллага	Огноо	Тогтоолын нэр (товч утга)
1	Улсын Их Хурал	2010.07.07	39 Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай
2	Засгийн газар	2010.10.20	272 “Эрдэнэс Тавантолгой” ХК байгуулах тухай
3	Засгийн газар	2010.12.29	350 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
4	Засгийн газар	2011.03.31	98 Монгол Улсын иргэнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх
5	Улсын Их Хурал	2011.11.30	57 Зарим арга хэмжээний тухай
6	Улсын Их Хурал	2012.02.16	18 Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай
7	Засгийн газар	2012.04.11	116 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
8	Засгийн газар	2012.05.30	181 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тухай
9	Засгийн газар	2012.06.13	201 “Журам батлах тухай”
10	Засгийн газар	2013.04.06	132 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны төлбөрийн тухай
11	Засгийн газар	2013.12.14	409 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай
12	Засгийн газар	2017.05.30	154 “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай
13	Улсын Их Хурал	2018.06.29	73 Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай
14	Засгийн газар	2018.08.08	245 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай
15	Засгийн газар	2019.07.09	296 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай
16	Засгийн газар	2022.05.31	220 Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлийн өр төлбөрийг барагдуулах зарим арга хэмжээний тухай
17	Улсын Их Хурал	2024.01.17	10 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай
18	Засгийн газар	2024.01.31	45 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай
19	Засгийн газар	2024.01.31	46 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн талаар авах зарим арга хэмжээний тухай
20	Засгийн газар	2024.01.31	47 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн талаар авах зарим арга хэмжээний тухай
21	Засгийн газар	2024.12.20	225 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн талаар авах зарим арга хэмжээний тухай
22	Засгийн газар	2025.02.05	65 “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай
23	Засгийн газар	2026.03.18	90 “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зарим арга хэмжээний тухай
24	Засгийн газар	2026.04.29	154 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Эх сурвалж: www.legalinfo.mn

1.4 Зарим тогтоол, шийдвэр нь төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгаас “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн аж ахуйн нэгж хооронд үүссэн өр, авлагад суутган тооцохоор гарсан байна. Тухайлбал;

- ЗГ-ын 2022 оны 220 дугаар тогтоолын 5-д ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2019 оны төрийн өмчийн ногдол ашиг 880.2 тэрбум төгрөгөөс 117.2 тэрбум төгрөгийг Эрдэнэс Монгол ХХК-д хуваарилахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д, хуваарилсан ногдол ашгийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн төлбөрт шилжүүлж, нягтлан бодох бүртгэлийн холбогдох бичилт хийж бүртгэхийг ... даалгасугай”,
- УИХ-ын 2024 оны 10 дугаар тогтоолын 3-д ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох”,
- ЗГ-ын 2024 оны 47 тогтоолын 1-д ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хуваарилж, хуваарилсан ногдол ашгаас “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн аж ахуйн нэгж хооронд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөртэй холбоотой үүссэн өр авлагад суутган тооцохыг ... даалгасугай”

1.5 Дээрх тогтоол, шийдвэрээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2019, 2022, 2023 оны ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхгүйгээр өр, авлагад суутган тооцох шийдвэр гаргасан нь Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1¹, 8 дугаар зүйлийн 8.2²-т /2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаас өмнөх зохицуулалт/ заасантай тус тус нийцээгүй байна.

Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчээс ирүүлж буй удирдамжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тогтоож байна.

1.6 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор³ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон ч 2021 оны 367 дугаар тогтоолоор⁴ “Эрдэнэс Монгол” ХХК байхаар шийдвэрлэсэн байна.

1.7 Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.2.4-т ногдол ашгийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх; гэж тусгасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-аас ирүүлсэн удирдамжийг үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг гаргаж байна.

1.8 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2 удирдамж, “Эрдэнэс Монгол” ХХК-аас 7 удирдамжийг тус тус ирүүлсэн байна. Үүнд:

¹ 7.1.1 ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;

² 8.2. Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор ашиглах, захиран зарцуулахыг хориглоно.

³ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай

⁴ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай

Дүрслэл 2. Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д ирүүлсэн ногдол ашиг олгохтой холбоотой удирдамжийн нэгтгэл



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

1.9 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2019-2025 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохтой холбогдуулан нийт 9 тогтоол гарсан байна.

1.10 Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д “Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна”, 46.8-д “Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна” гэж тус тус заасан байхад ТУЗ-өөс дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- 2022 оны ногдол ашиг хуваарилах эсэх талаарх шийдвэрийг “...ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг компанид тогтоосон онцгой дэлгэмийн хугацаа дууссаны дараа авч үзэхээр тогтоосугай.” гэж 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр буюу хугацаа хоцроож,
- 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр буюу санхүүгийн жил дуусаагүй байхад 2024 оны ногдол ашгаас урьдчилгаа олгох шийдвэр тус тус гаргасан байна.

1.11 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийт 15.0 тэрбум ширхэг зарласан хувьцаатай ба 933 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 12.0 тэрбум хувьцаа гаргасан байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчийн бүртгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэл/2025.12.31-ний байдлаар/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьцааны тоо, ширхэгээр
1	“Эрдэнэс Монгол” ХХК	1	8,820,160,578
2	Аж ахуй нэгж	488	7,065,038
3	Иргэд	3408021	3,172,774,384
Нийт дүн		-	12,000,000,000

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Эрх бүхий байгууллага хоорондын уялдаа хангалтгүй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, мэдээллийн үнэн зөв байдлыг алдагдуулж байна.

1.12 Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, өмчлөх эрхийг баталгаажуулах нэгдсэн бүртгэлийн үйл ажиллагааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК хариуцан гүйцэтгэхээр баталсан байна.

1.13 Үүнээс хойш нийт 3744229 иргэнд 4,057,062,783 ширхэг хувьцаа эзэмшүүлсэн ба Засгийн газрын 2010 оны “Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга

хэмжээний тухай” 347 дугаар тогтоол, 2016 оны “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” 334 дүгээр тогтоол болон бусад шийдвэрээр сайн хувьцаа, сургалтын төлбөр, эрүүл мэндийн даатгал болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хишиг хувь хэлбэрээр хувьцааг буцаан худалдан авч, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3408021 иргэний 3,172,774,384 ширхэг хувьцаа нэгдсэн бүртгэлд байна.

1.14 “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь хувьцаа эзэмшигчийн нэгдсэн бүртгэлийг хөтлөхдөө хувьцаа эзэмшүүлэхээс өмнө Монгол Улсын харьяатаас гарсан иргэдийг бүртгэсэн нь хувьцааг “Монгол Улсын иргэн”-д эзэмшүүлэхээр заасан Засгийн газрын тогтоолуудтай нийцээгүй, мөн хугацаанаас өмнө нас барсан иргэдэд өмчлөх эрх олгож бүртгэсэн нь Иргэний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1⁵, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7⁶, 42.10⁷, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2019 оны №02/02 дугаар гэрээний 7.1⁸, 7.2⁹ дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

1.15 Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нас барсан 135798 иргэн, харьяатаас гарсан 13823 иргэн бүртгэлтэйгээс хувьцаа эзэмшүүлэхээс өмнө нас барсан болон харьяатаас гарсан нийт 1988 иргэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Хувьцаа эзэмшүүлэхээс өмнө Монгол Улсын харьяатаас гарсан, нас барсан иргэд

Төлөв	Хувьцаа эзэмших боломжгүй иргэдийн тоо	Хувьцаа эзэмшүүлэх хугацаанаас өмнөх иргэдийн тоо	УБЕГ-т бүртгэгдсэн хугацаа тодорхойгүй	Анх эзэмшсэн хувьцааны тоо ширхгээр	2025.12.31-ний байдлаарх хувьцааны үлдэгдэл ширхгээр
Харьяатаас гарсан	1578	1482	96	1,689,472	1,685,760
Нас барсан	410	388	22	433,624	425,299
Нийт дүн	1988	1870	118	2,123,096	2,111,059

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Улсын бүртгэлийн ерөнхий газар

1.16 Хувьцаа эзэмшүүлэхээс өмнө Монгол Улсын харьяатаас гарсан 1482 иргэний 1,685,760 ширхэг хувьцаа, мөн нас барсан 388 иргэний 425,299 ширхэг хувьцаа тус тус бүртгэлтэй байна.

1.17 Хувьцааны бүртгэлийн үнэн зөв байдал хангалтгүй байгаагаас хувьцаа эзэмшүүлэх хугацаанаас өмнө харьяатаас гарсан 16 иргэний 3,712 ширхэг хувьцаа, нас барсан 17 иргэний 8,325 ширхэг хувьцааг төрийн өмчлөлд буцаан худалдсан боловч хувьцааны нэгдсэн бүртгэлд уг гүйлгээний төрөл, эрх зүйн үндэслэл нь тодорхойгүй байна.

1.18 Монгол Улсын иргэний бүртгэлд хүчингүй регистрийн дугаартай болон регистрийн дугаараа сольсон иргэд хувьцаа эзэмшигчийн бүртгэлд давхар бүртгэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 4. Хүчингүй регистрийн дугаартай болон бүртгэл давхардсан иргэдийн бүртгэл

Төлөв /регистрийн дугаар/	Хувьцаа эзэмшигч иргэдийн тоо	Анх эзэмшүүлсэн хувьцааны тоо	2025.12.31-ний байдлаарх хувьцааны үлдэгдэл ширхгээр	Төрд худалдсан	
				Иргэд	Хувьцааны тоо
Хүчингүй РД-тай иргэд	6272	6,723,584	6,720,750	103	2,834
РД давхардсан иргэд	2449	2,624,792	2,304,514	701	320,278
Шинэ РД-аар бүртгэлгүй иргэд	49	-	-	-	-

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Улсын бүртгэлийн Ерөнхий газар

⁵ 14.1-д 14.1.Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно.

⁶ 42.7.Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээлэл, баримтыг хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд бүрэн бүтэн хадгалж, зохих журмын дагуу мэдээлэх буюу тайлагнах үүрэгтэй.

⁷ 42.10 Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд алдаатай мэдээлэл оруулсны улмаас учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

⁸ 7.1-д Хадгалагч хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийн үнэн зөвийг хариуцах бөгөөд Хадгалуулагчийн хувьцааны бүртгэлийг Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоол болон холбогдох бусад Улсын Их хурал, Засгийн газрын тогтоолд заасан нөхцөл тус бүрийг хангаж үзнэ.

⁹ 7.2-д Энэ гэрээний 7.1-д заасныг зөрчсөний улмаас үүсэх бүх хариуцлагыг Хадгалагч хүлээх бөгөөд өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бүртгэлийг буруу хийсэн буюу хувьцаатай холбогдох нөхцөлийг хангаагүй тохиолдолд өөрийн алдааг нэн даруй засаж залруулах үүрэгтэй.

1.19 Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн бүртгэлд хүчингүй регистрийн дугаартай 6272 иргэний 6,723,584 хувьцааг бүртгэснээс регистрийн дугаар өөрчлөгдсөн 2449 иргэний 2,624,792 хувьцааг давхар бүртгэсэн ба 49 иргэнийг хувьцаа эзэмшигчээр бүртгээгүй байна.

1.20 Регистрийн дугаараа өөрчилсөн иргэдийн хүчингүй бүртгэлийн хувьцааны үлдэгдлийг шинэ регистрийн дугаараар шилжүүлэн бүртгэхдээ 35 иргэний эзэмшиж байсан 35,952 ширхэг хувьцааг 37,740 ширхэг гэж 1,788 ширхэг хувьцааг үндэслэлгүйгээр илүү бүртгэсэн байна.

1.21 Мөн регистрийн дугаараа шинэчилсэн 2449 иргэнийг бүртгэхдээ 2156 иргэний 2,311,232 ширхэг хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөр, 66 иргэний 70,752 ширхэг хувьцааг 2023 оны 12 хувьцааны 31-ний өдрөөр тус тус хүчингүй регистрийн дугаартай давхардуулан бүртгэсэн байна.

1.22 Энэ нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн үнэн зөв байдлыг хариуцах чиг үүрэг бүхий 'Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв' ХХК-ийн үнэт цаасны шилжилт хөдөлгөөнд тавих дотоод хяналт, хэрэгжилт сул байгааг харуулж байна.

1.23 Иймд хувьцаа эзэмших боломжгүй иргэдийг бүртгэлээс хасч, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, Монгол Улсын харьяатаас гарсан, нас барсан хугацаа тодорхойгүй иргэдийн хугацааг УБЕГ-тай хамтран тодорхой болгож, бүртгэлийн алдааг залруулах, регистрийн дугаараа шинэчилсэн иргэдийн өмнөх хүчингүй регистрийн дугаараар бүртгэлтэй хувьцааг шилжүүлэн бүртгэх, Монгол Улсын харьяатаас гарсан иргэдийг хувьцааны бүртгэлээс хасах эрх зүйн орчныг тодорхой болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.24 Засгийн газрын 2026 оны ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 154 дүгээр тогтоолоор нас барсан иргэдийн хувьцааны ногдол ашгийг хууль ёсны өвлөгчид шилжүүлэхээр шийдвэрлэсэн тул уг бүртгэлийн зөрчил, зөрүүг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага үүсэж байна.

1.25 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэд, аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх шийдвэр нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны шугамаар хэрэгжээгүйгээс шалтгаалан “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн мэдээллийн “E-Clearing House” системийн үндсэн цэсээр бүртгэл хийгдээгүй, Улсын бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан гар аргаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийсэн байна.

1.26 Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг системд бодит цагийн (Real-time) горимоор гүйцэтгэдэггүй, төрийн эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох системийн уялдаа, холбоогүй байгаа нь мэдээллийн үнэн зөв, бодитой байдал алдагдах, цаг хугацааны хоцрогдол үүсэх зэрэг эрсдэл үүсгэхээр байна.

1.27 Засгийн газрын 2024 оны 45 дугаар тогтоолоор хувьцаа эзэмших иргэдийн нэр, оршин суугаа хаяг болон иргэд үнэт цаасны данс нээлгэх, бүртгэхтэй холбоотой харилцааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д иргэдийн мэдээллийг боловсруулж, бүртгэлийг цахимжуулж, мэдээллийг шуурхай солилцож ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгасан ч тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

1.28 Цаашид “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмших боломжгүй иргэдийн бүртгэлийг залруулах, хувьцаа олгосноос хойш Монгол Улсын харьяатаас гарсан иргэдийн хувьцаа эзэмших бүртгэлийг цуцлах, төрийн өмчлөлд шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг тодорхой болгох, программ хангамжийг сайжруулах шаардлагатай байна.

Компанийг нээлттэй болгож, хувьцааг энгийн хэлбэрт шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангагдаагүй байна.

1.29 Засгийн газраас 2010 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг байгуулж, байгалийн баялгийн үр өгөөжийг иргэдэд тэгш хүртээх зорилгоор Монгол Улсын иргэн бүрд 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгон 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлсэн ба хувьцааг энгийн хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой дараах тогтоол, шийдвэр гарсан байна.

Дүрслэл 3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой УИХ, ЗГ-ын шийдвэрүүд




Эх сурвалж: www.legalinfo.mn

1.30 Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 45 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг энгийн хувьцаанд бүртгэх болсонтой холбоотой зарим асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дараах ажил хийгдэж байна. Үүнд:

- Нас барсан иргэний хувьцаа, ногдол ашгийг өвлөх – ЗГ-ын 2026 оны 154 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаад нас барсан 132.7 мянган иргэний 111.29 сая ширхэг (≈ 103.8 тэрбум төгрөг) хувьцаа болон түүнд ногдох 66.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг өвлүүлэхээр шийдвэрлэсэн. Дараах асуудлууд танилцуулга болон процессын үе шатанд явагдаж байна.
- Хишиг, хувь хүртэж хувьцаагаа хасуулсан болон Засгийн газарт худалдсан хувьцаагаа нэрлэсэн үнээр нь буцаан худалдан авах-Нийт 2.5 сая иргэний 886.3 сая ширхэг хасагдсан хувьцаа болон “Сайн хувьцаа” арга хэмжээний хүрээнд 1.2 сая иргэний 386.3 сая ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр буцаан худалдан авах,
- 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн хүүхдэд 1072 хувьцаа эзэмшүүлэх – Тухайн хугацаанаас хойш төрсөн 124.1 мянган хүүхдэд 132.9 сая ширхэг буюу тус бүр 1072 хувьцаа үнэ төлбөргүй эзэмшүүлэх,
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урьдчилсан тооцоогоор шинээр төрсөн иргэдэд хувьцаа олгох болон өмнө нь хувьцаагаа худалдсан, хишиг хүртсэн иргэдэд буцаан олгох ажлыг хэрэгжүүлснээр нийт гаргасан хувьцааны 4,192.1 сая ширхэг (34.9%) нь иргэдийн эзэмшилд шилжиж, төрийн эзэмшлийн хувьцаа 7,800.9 сая ширхэг (65.0%) болж буурахаар тооцоолсон байна.

1.31 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох эрх бүхий байгууллагын шийдвэр гаргах, компанийн бүтэц, дүрэмд шаардлагатай өөрчлөлт оруулах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлэх, улмаар хувьцааг олон нийтэд санал болгох (IPO) болон хоёрдогч зах зээлд арилжаалах хүртэлх дараалсан дараах үе шатуудаас бүрдэнэ. Үүнд:

Дүрслэл 4. Нээлттэй хувьцаат компани болгох хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанд нээж, арилжаалах хүртэлх хууль, эрх зүйн шаардлага



1.32 Хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанд нээж, арилжаалах бэлтгэл ажлын хүрээнд олон улсын аудитын үйлчилгээ хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү аудитын үр дүнгээс хамааран андеррайтерийн зөвлөх сонгох, хууль зүйн дүгнэлт гаргуулах, хөрөнгийн үнэлгээ хийх зэрэг дараагийн бэлтгэл ажлууд үе шаттайгаар хэрэгжихээр хүлээгдэж байна.

1.33 Мөн компанийн засаглалын кодекст нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, хараат бус байдлыг бэхжүүлэх, ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг оновчтой тусгаарлах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.34 Дээрх асуудлыг шийдвэрлэснээр компани нээлттэй хувьцаат компанийн шаардлагыг хангаж, хувьцааг энгийн хэлбэрт шилжүүлэн олон нийтэд санал болгож, хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөл бүрдэхээр байна.

¹⁰ 2.6.Энэ хуулийн 2.5-д заасны дагуу үүссэн төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал, ... этгээд байж болно.

¹¹ 23.1.Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу компанийг өөрчлөх төслийг.....хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

БҮЛЭГ 2. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК НЬ ТӨРД НОГДОХ НОГДОЛ АШГИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЗАРДЛЫГ ОНОВЧГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Хамаарал бүхий компаниудад олгосон санхүүжилт компанийн ашигт ажиллагаанд шууд нөлөөлөхгүй ч ирээдүйд эрсдэл бий болох нөхцөл бүрдэж байна.

2.1 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн харьяанд “Тавантолгой төмөр зам” ХХК, “Тавантолгой түлш” ХХК нь охин компани хэлбэрээр, “Гашуун сухайт авто зам” ХХК, “Тавантолгой дулааны цахилгааны станц” ХХК нь хараат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүрслэл 5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн охин болон хараат компанийн хувь эзэмшил, шийдвэр



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

2.2 Охин болон хараат компаниуддаа 2018-2026 оны хооронд дараах санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Хүснэгт 5. Охин болон хараат компаниудад олгосон санхүүжилт, тэрбум төгрөгөөр

№	Компани	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	Нийт
“Тавантолгой төмөр зам” ХХК		-	505.7	521.3	426.8	850.5	1,296.2	121.7	254.7	-	3,976.9
1	ТТ-ГС ¹² чиглэлийн төмөр зам төсөл	-	505.7	521.3	348.0	412.8	1,199.8	78.3	-	-	3,065.9
	Мөнгөөр	-	308.9	-	-	-	-	-	-	-	308.9
	Нүүрсээр	-	196.8	521.3	348.0	412.8	1,199.8	78.3	-	-	2,757.0
	ГС-ГМ ¹³ боомтын хил дамнасан төмөр зам төсөл	-	-	-	-	-	-	-	254.7	-	254.7
3	ТТ-ГС ¹⁴ , ТТ-ЗБ холболтын төмөр зам төсөл	-	-	-	-	218.0	-	-	-	-	218.0
4	Тавантолгой нүүрс ачих логикийн төв төсөл	-	-	-	78.8	88.8	96.4	43.4	-	-	307.4
5	Богдхан төмөр зам төсөл	-	-	-	-	130.9	-	-	-	-	130.9
“Тавантолгой түлш” ХХК		18.6	111.8	138.7	180.8	352.2	265.4	281.0	280.0	145.0	1,773.5
1	Мөнгөөр	18.6	111.8	138.7	180.8	339.7	265.4	281.0	280.0	145.0	1,761.0
2	Нүүрсээр	-	-	-	-	12.5	-	-	-	-	12.5
“Тавантолгой дулааны цахилгаан станц” ХХК		-	-	-	5.7	7.0	-	-	-	-	12.7

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

2.3 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь охин болон хараат компаниудын хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт болон эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр нийт 5,763.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2018-2026 онд олгосон байна.

¹² Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам төсөл

¹³ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан

¹⁴ Тавантолгой-Гашуунсухайт¹⁴, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох холболтын төмөр зам төсөл

“Тавантолгой түлш” ХХК-д олгосон санхүүжилтийн эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

2.4 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Тавантолгой түлш” ХХК-тай 2018 оноос хойш эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн 20 гэрээ байгуулж, компанийн үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтад нийт 1,761.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 2021-2025 оны хооронд эргэн төлөлт нь хийгдэж эхлэх байсан 7 гэрээний хугацааг 1-2 удаа сунгаж, гэрээний эргэн төлөлт огт хийгдээгүй байна.

2.5 Санхүүжилтийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь компанийн мөнгөн урсгалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн төлөвлөлт болон төлбөрийн чадварыг алдагдуулах, цаашдын хөрөнгө оруулалт татах болон дотоод, гадаад санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломжийг хязгаарлах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.

2.6 Түүнчлэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/307 дугаар, 2023 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд “Тавантолгой түлш” ХХК-д олгосон 2018-2022 оны санхүүжилтэд хяналт шалгалтыг хийж, дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал;

- А/307 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр 2018-2022 онд хөрөнгө оруулалтад санхүүжүүлсэн 286.8 тэрбум төгрөгөөс 110.6 тэрбум төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан,
- А/02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр “Эрдэнэс Тавантолгой”-2022/83 дугаартай гэрээний дагуу Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, түүний бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон эхний санхүүжилт болох 34.6 тэрбум төгрөгийг гэрээнд заасан зориулалтын дагуу бус компанийн үндсэн үйл ажиллагаа болон түүхий эд, өмнөх оны өр төлбөрт шилжүүлэн зарцуулсан гэх мэт...

2.7 Дээрх зөрчлийг шалгуулахаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2023 оны 03 дугаар сарын 10-ны 01/361 албан бичгээр Сангийн яаманд, 01/362 албан бичгээр Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэст хүргүүлсэн ч 2026 оны 05 дугаар сарын байдлаар шийдвэрлэгдээгүй байна.

2.8 Харин 2023-2025 оны хооронд олгогдсон санхүүжилт гэрээний дагуу зарцуулагдсан эсэхэд хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь гэрээний 5.1-д “Тавантолгой түлш” ХХК нь гэрээний дагуу олгосон санхүүжилтийг зөвхөн...зардлыг санхүүжүүлэх зорилгоор ашиглах үүрэгтэй”, 6.1-д “Эрдэнэс Тавантолгой” ХК нь энэхүү гэрээний эрх, үүргийг хэрэгжүүлэн хяналт тавин ажиллана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.9 Иймд компанийн зүгээс “Тавантолгой түлш” ХХК-д олгосон санхүүжилт гэрээний дагуу зарцуулагдсан, үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон эсэхэд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.


2.10 Мөн Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 18 дугаар тогтоолоор “Тавантолгой түлш” ХХК-ийн хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д үүрэг болгосон ч 2026 оны 05 дугаар сарын байдлаар хэрэгжээгүй байна.

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг “Монголын төмөр зам” ХХК-д нэгтгэсэнтэй холбоотойгоор оруулсан хөрөнгө оруулалтыг зээлийн гэрээнд шилжүүлсэн байна.

2.11 Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг байгуулах, тус хуулийн этгээдэд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр тогтоосон бол 2022 оны 434 дүгээр тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, “Монголын төмөр зам” ТӨХК-д нэгтгэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.

2.12 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2020-2023 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалт хэлбэрээр “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэйгөөр дараах санхүүжилтийг олгосон байна.

Дүрслэл 6. “Зүүнбаян төмөр зам” ХХК-д олгосон санхүүжилт, тэрбум төгрөгөөр



2.13 “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК 66 хувийн хөрөнгө оруулалтын үр өгөөжөө хүртэх боломжгүй болж, төслийн бүтээн байгуулалтад зарцуулсан 586.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон зээлд тооцохоор тохиролцож ЭТТ-2023/1521 дугаартай “Санхүүжилтийн гэрээ”-г байгуулсан байна.


2.14 Мөн “Монголын төмөр зам” ТӨХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай 2024 онд төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай 41.5 тэрбум төгрөгийг 20 жилийн хугацаатай, жилийн 10.87 хувийн хүүтэй “Санхүүжилтийн гэрээ” байгуулан, зээлээр санхүүжүүлсэн байна.

2.15 Үүнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д Үндэсний аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар компани нь банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэслэлгүй боловч зээл олгосон зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй төсөлд санхүүжилт олгож байна.

2.16 Улсын Их хурлын 2018 оны 73 дугаар¹⁵ тогтоолоор “...Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх” гэж тусгасны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019-2025 онуудад томоохон төслүүд, компанид хийгдэх хөрөнгө оруулалтад нийт 13,499.9 тэрбум төгрөг төсөвлөж, 8,918.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Үүнд:

Дүрслэл 7. Хөрөнгө оруулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл, сая төгрөгөөр



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

¹⁵ “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”

2.17 Дээрх дүрслэлээс харахад 2019-2025 онд компанид хийгдэх хөрөнгө оруулалт, он дамжих болон бусад хөрөнгө оруулалтад нийтдээ 1,692.8 тэрбум төгрөгийг зарцуулж, харин томоохон төслийг хэрэгжүүлэхэд 7,225.4 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.18 Томоохон төслийн хүрээнд эрчим хүч, төмөр зам, шилжүүлэн ачих терминал, бүтээн байгуулалтын болон нэмүү өртөг шингээх зэрэг чиглэлд дараах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн байна. Тухайлбал;

Хүснэгт 6. Томоохон төслүүдийн товч мэдээлэл /2025.12.31-ний байдлаар/

Төслийн нэр	Валютын төрөл	Гэрээний дүн	Төслийн гүйцэтгэл, хувиар	Хэрэгжих хугацаа /он/	
				Эхлэх	Дуусах
Тавантолгой–Гашуунсухайт төмөр замын цогцолбор төсөл	сая ам.доллар	1,005.6	98.7	2019	2024
Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалт	сая ам.доллар	388.1	89.8	2022	2024
Тавантолгойн нүүрс ачих логикийн төв	тэрбум төгрөг	313.2	99.9	2022	2024
Нүүрс баяжуулах үйлдвэр	тэрбум төгрөг	1,087.9	99.0	2022	2025
Шилжүүлэн ачих терминал	сая.ам.доллар	32.7	100.0	2022	2023
Гашуунсухайт–Ганцмод хил дамнасан төмөр зам	тэрбум төгрөг	848.9	8.1	2025	2027

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

2.19 Үүнээс Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар¹⁶ тогтоолоор дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зураг төслийн дагуу БНХАУ-ын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас санхүүжүүлэх;
- БНХАУ-ын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд үе шаттайгаар жил бүр 20 сая тонноос доошгүй хэмжээний нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацааны худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх; гэх мэт...

2.20 Улсын Их хурлын 2023 оны “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” 63 дугаар тогтоолоор “...төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” хувьцаат компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгах аар тогтоосугай.” гэж заасан байна.

2.21 Уг хянан шалгах түр хорооноос хийсэн хяналт шалгалттай холбогдуулан Улсын Их хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолын 3 дахь заалтад “Эрдэнэс Тавантолгой” ХК...цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах;” гэж тусгасан байхад дараах гэрээг байгуулж, санхүүжилт олгосон байна. Үүнд:

- “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” компани нарын хооронд ““Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ”-г 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр,
- “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК хооронд уг санхүүжилтийг эргэн төлөх гэрээг 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр тус тус байгуулсан байна.

2.22 Иймд ““Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг цаашид санхүүжүүлэхгүй байх, 2025 онд олгосон 240.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг

¹⁶ “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай”

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашгийн өглөгөөс суутган тооцох нь зүйтэй байна.

Менежментийн үйлчилгээний төлбөр нь компанийн цаашдын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

2.23 “Эрдэнэс Монгол” ХХК-аас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бизнесийн стратегийг нэгтгэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, оновчтой шийдэл гаргах, шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлж шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчид өгөх, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагааны; санхүүгийн; геологи хайгуул, үйлдвэрлэл технологи; хүний нөөцийн; хууль эрх зүй, засаглал, нийцлийн; байгаль орчны зэрэг менежментийн 6 үйлчилгээ үзүүлэх гэрээг 2023 онд байгуулсан байна.

2.24 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь менежментийн үйлчилгээ үзүүлсний төлбөрт 2023-2025 онд нийт 206.1 тэрбум төгрөг шилжүүлсэн ба сүүлийн 3 жилийн орлого, зардал дараах байдалтай байна.

Хүснэгт 7. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлого, зардлын дүн, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2023	2024	2025
Орлого	9,547.9	10,250.7	6,046.2
Зардал	4,895.6	4,539.1	5,261.4

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын баталгаажуулсан аудитын тайлан 2023-2025 он

2.25 Дээрх хүснэгтээс харахад орлого 2024-2025 онд 36 хувиар буурч, зардал 15.9 хувиар өссөн, цэвэр ашиг 75 хувиар багассан нь менежментийн үйлчилгээ үр дүнгүй байгааг харуулж байна.

2.26 Гэрээний 5.9-д “Нэгдлийн охин, хараат компани болон харьяа хуулийн этгээд нь тухайн санхүүгийн жил алдагдалтай ажилласан нь менежментийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан нь гэрээний үндсэн зорилгод нийцээгүй, гэрээний үр дүнг тооцохгүй төлбөрийг бүрэн олгож байгаа нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн цаашдын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2.27 Менежментийн үйлчилгээ үзүүлэх 2023 оны гэрээний төлбөрөөс нэгдлийн харьяа охин компаниудын алдагдлыг нөхөх, хэвийн үйл ажиллагааг хангах, толгой компанийн өрийг дараах байдлаар суутган шилжүүлсэн байна.

Хүснэгт 8. Гэрээний төрөл, үнийн дүнгийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр

Гэрээний нэр, Гэрээний төрөл, тухайн гэрээний мессеж, төрөл, нэр, өдөр					
№	Гэрээний огноо	Компанийн нэр	Гэрээний төрөл	Гэрээний дүн	Суутгасан үнийн дүн
1	2021.01.18	“Эрдэнэс Монгол” ХХК	Авлага барагдуулах гэрээ	61.4	61.4
2	2018.06.07	“Эрдэнэс Монгол” ХХК,	Зээлийн гэрээ	13.9	14.7
3	2023.02.20	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Багануур ХХК”		14.6	15.2
Нийт					91.4

Эх сурвалж: Менежментийн үйлчилгээ үзүүлэх 2023 оны гэрээ, мөнгөн гүйлгээний баримтууд

2.28 “Багануур” ХХК-тай 2018 онд байгуулсан гурван талт зээлийн гэрээний 2.1.1-д “...зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлөөгүй, эргэн төлөлтийн хуваарийг мөрдөж ажиллаагүй тохиолдолд зээлийн санхүүжилт, түүнд оногдох хүүг “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2019-2020 онд “Эрдэнэс Монгол” ХХК-д хуваарилах компанийн ногдол ашиг болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн менежментийн төлбөрөөс суутган тооцуулах үүрэгтэй” гэж тусган ашигтай ажиллаж байгаа компаниар хөрөнгийн алдагдалтай компанийн өр төлбөрийг барагдуулах, хэвийн үйл ажиллагааг хангахаар зохицуулсан байна.

2.29 Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоол, ЗГХЭГ-ийн ХЭГ/2808 дугаар албан бичиг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 25 дугаар тогтоол, 01/690 дугаар албан бичгийг тус тус үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2017 оноос хойш алдагдалтай ажиллаж байгаа “Багануур” ХХК-д дахин 14.6 тэрбум төгрөг буюу нийт 28.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

2.30 Засгийн газар нь хуульд нийцүүлсэн шийдвэр гаргах бүрэн эрхийг Үндсэн хуулиар олгосон бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдэд илт хохиролтой шийдвэр гаргасан нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3¹⁷ дахь хэсэгт заасантай нийцээгүй байна.

2.31 Менежментийн үйлчилгээ нь тухайн санхүүгийн жилд¹⁸ хийж гүйцэтгэсэн ажлын төлбөр байх ба гэрээний төлбөрийг жил бүр хавсралтаар баталж, хуваарийн дагуу төлөхөөр гэрээнд тусгасан ч дараах байдлаар гэрээг байгуулж, үйлчилгээний төлбөрийг төлсөн байна.

Хүснэгт 9. Борлуулалтын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

он	Гэрээ байгуулсан огноо	Борлуулалтын орлогын батлагдсан төлөвлөгөө	Борлуулалтын орлогын гүйцэтгэл /цэвэр/	Үйлчилгээнд төлсөн нийт төлбөр	Борлуулалтын орлогын хувь	Дараа оны зөрүү төлбөр
2023	2023.12.28	11,103.5	9,547.9	89.55	2	25.3
2024	2024.12.30	11,201.6	10,250.7	86.56	1	9.5
2025	2025.12.31	6,693.6	6,046.2	30.0	1	

Эх сурвалж: Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, мөнгөн гүйлгээний баримтууд

2.32 Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг тухайн оны сүүлд байгуулсан, тухайн жилийн борлуулалтын бодит орлогоос үл хамааран борлуулалтын төлөвлөгөөнөөс тооцож санхүүжилтийг олгож, дараа онд зөрүүг тооцож байгаа нь тухайн санхүүгийн жилийн тайлан бодитой бус байх эрсдэл үүсгэх, 2023 оны гэрээний холбогдох заалт¹⁹, 2024 оны гэрээний нэмэлт өөрчлөлтийн 2.1²⁰-т заасныг тус тус зөрчсөн байна.

2.33 “Эрдэнэс Монгол” ХХК-аас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д менежментийн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө тусгайлан баталдаггүй, гэрээний 5.3-д “Менежментийн үйлчилгээний төлбөрийг компаниуд харилцан тохиролцсоны үндсэн дээр акт үйлдэж хоорондын тооцооноос хасаж тооцож болно” гэж тусгасан нь гэрээний гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлэхгүйгээр төлбөрийг бүрэн олгох, хариуцлага тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.34 Эдийн засгийн тооцоололгүй борлуулалтын орлогын 2 хувь, 1 хувь гэж харилцан тохиролцож төлбөрийг бүрэн олгосон, гэрээг баталгаажуулахаас өмнө урьдчилгаа шилжүүлсэн нь Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 3.5.2²¹, 3.5.3²² дахь заалт, гэрээний 7.4²³, Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1²⁴ дэх хэсгийг тус тус зөрчсөн байна. Иймд менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, эдийн засгийн тооцоолол, борлуулалтын орлого, гүйцэтгэлийн хувь хэмжээнд үндэслэж төлбөрийг тогтоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

²⁷ 84.4.3-д компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

¹⁸ 1.3.3-д “санхүүгийн жил” гэж нэгдлийн охин, хараат компанийн болон, харьяа хуулийн этгээдийн дүрмээр тогтоосон хугацаа буюу тухайн жилийн 1 сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хуанлийн хоногоор тооцно.

¹⁹ 5.1-д Толгой компани нь нэгдлийн компаниудад менежментийн үйлчилгээ үзүүлсний төлбөрийг дараах байдлаар тооцно. Менежментийн төлбөр= (Санхүүгийн жилийн борлуулалтын орлого*хоёр хувь) 5.2-д Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болмогц охин, хараат компани, харьяа хуулийн этгээд нь 2023 оны төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаагаар төлөх бөгөөд цаашид жил бүрийн менежментийн төлбөрийг улирал бүрийн сүүлийн сарын 30-ны дотор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Голомт банкны ... тоот дансанд шилжүүлнэ. 5.5-д Эхний 3 улирлын төлбөрийн тухайн жилийн батлагдсан төсвөөс гэрээнд заасан хувиар тооцон төлнө. Сүүлийн улирлын менежментийн төлбөрийг тухайн жилийн гүйцэтгэлээс тооцсон дүнгээс эхний 3 улиралд төлсөн төлбөрийг хасаж зөрүүг төлнө

²⁰ 2.1-д Талууд үндсэн гэрээний 5.1-д заасан менежментийн үйлчилгээ үзүүлсний төлбөрийн хувь хэмжээг 2024 онд Санхүүгийн жилийн борлуулалтын орлогын нэг хувь байхаар харилцан тохиролцов.

²¹ 3.5.2-д Компани нь охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжтэй менежментийн гэрээ байгуулж, дүгнэнэ

²² 3.5.3-т заасан гэрээний дагуу охин, хараат компани, харьяа хуулийн этгээд компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээ нь борлуулалтын орлогын 2 (хоёр) хүртэл хувь байна

²³ Гэрээний 7.4-д Менежментийн үйлчилгээ үзүүлэх 2023 оны гэрээний Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлснээр дуусгавар болгоно

²⁴ 13.1 дүгээр зүйл “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ”

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

2.35 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч 2023-2025 онуудад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд жилд дунджаар 3 удаа тодотгол хийсэн байна.

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Хэрэгжээгүй	
	Анхны төсөвт өртөг	Тодотгосон						
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо /багц/	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
2023	1,092.9	513	4,070.7	561	210	2,580.9	351	1,489.7
2024	1,950.4	546	7,220.7	669	282	5,903.2	387	1,317.4
2025	3,658.4	582	5,331.9	692	291	1,105.0	401	4,226.8
Нийт	6,701.7	1641	16,623.3	1922	783	9,589.2	1139	7,034.1

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2023-2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан

2.36 Төлөвлөгөөнд тодотгол хийгдсэнээр анх баталсан төсөвт өртөг нэг жилд 3.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.37 “Эрдэнэс Тавантолгой” ХК 2023-2025 онд 16,623.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1641 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 1922 төсөл, арга хэмжээг багцлан, хэрэгжүүлж гүйцэтгэлээр 9,589.2 тэрбум төгрөгийн 783 төсөл, арга хэмжээний гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан байна.

2.38 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 37.4-42.0 хувьтай, “хангалтгүй” байгаа нь хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, төлөвлөлтөд олон удаа өөрчлөлт хийсэн, гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, төсөвт өртөг, хэрэгжүүлэх хугацааг үндэслэлгүйгээр төлөвлөсөн байна. Тухайлбал;

- 2023 онд 269.5 тэрбум төгрөгийн 187 төсөл арга хэмжээ, 2024 онд 1,044.4 тэрбум төгрөгийн 167 төсөл арга хэмжээ, 2025 онд 750.1 тэрбум төгрөгийн 217 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийг огт зарлаагүй,
- Гэрээ байгуулагдаж амжилттай болсон тендерээс 2023 онд 2,734.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 128 төсөл арга хэмжээ, 2024 онд 5,995.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 202 төсөл арга хэмжээ, 2025 онд 811.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 174 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн хугацааг баримтлаагүй, мөн 2023 онд 1.0 тэрбум төгрөгийн 65 төсөл арга хэмжээний худалдан авалтын зохион байгуулах хугацаа тодорхой бус “тухай бүр” гэж төлөвлөсөн.

2.39 Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 44 дүгээр зүйлийн 44.1²⁵, 48 дугаар зүйлийн 48.2.1²⁶, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.9²⁷, 4.1.5²⁸ дахь заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

2.40 Зарим төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан тендер шалгаруулалтын журмын дагуу сонгон шалгаруулаагүй гэрээг шууд байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 10 дугаар зүйлийн 10.2²⁹, 18 дугаар зүйлийн 18.1³⁰ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал;

²⁵ 44.1 Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

²⁶ 48.2.1 худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;

²⁷ 2.9-д Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална

²⁸ 4.1.5-д төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалт зарласан эсэх;

²⁹ 10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.

³⁰ 18.1.Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана.

- 2023 онд 455.5 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар төлөвлөснөөс 7 төсөл, арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулж 88.5 сая төгрөгийн гэрээ,
- 2024 онд 83.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар төлөвлөснөөс 18.1 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулсан.

2.41 Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарын дагуу сонгон шалгаруулалтын аргыг баримтлахгүй төсөвт өртгийг хувааж, гэрээг шууд байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 10 дугаар зүйлийн 10.3³¹ дахь хэсгийг зөрчсөн байна. Тухайлбал;

- 2023 онд 140.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах ажиллагааны журмаар баталж, 43.8 сая төгрөгийн нийт 21 ААН, 3 иргэнтэй,
- 2024 онд 282.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах ажиллагааны журмаар баталж, 117.3 сая төгрөгийн нийт 9 ААН-тэй,
- 2025 онд 3,062.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах ажиллагааны журмаар баталж, 810.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг нийт 63 ААН, 2 иргэнтэй гэрээг тус тус байгуулсан.

2.42 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2023 онд магадлашгүй, болзошгүй гэсэн нэршлээр төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаараар төлөвлөсөн, 2024-2025 онд энэ төрлийн төсөл арга хэмжээний гэрээг шууд байгуулах аргаар зохион байгуулсан нь үндсэн үйл ажиллагаанд хамаарах, жил бүр давтагддаг төсөл арга хэмжээний гэрээг шууд байгуулах, төсөл, арга хэмжээнд хамааралгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах эрсдэл үүсэхээр байна. Тухайлбал;

- 2023 онд 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “10 кВ-н ЦДАШ дэд станцын засварын ажил, 0.4 кВ-н цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ” худалдан авах төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар төлөвлөж шууд гэрээ байгуулсан бол 2025 онд 65.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлан харьцуулалтын аргаар зохион байгуулж, 59.0 сая төгрөгөөр,
- 2023 онд 57.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хэрэглээний программын лицензүүд худалдан авах” төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар төлөвлөж шууд гэрээ байгуулсан бол 2025 онд 197.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлан нэлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, 178.8 сая төгрөгөөр,
- 2025 онд 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах маркетингийн үйл ажиллагааг “Болзошгүй үеийн маркетингийн зардал” гэх нэршлээр шууд худалдан авалтын аргаар төлөвлөж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 15 жилийн ойн баярын бэлтгэл ажил болон бусад үйл ажиллагаанд нийт 471.4 сая төгрөгийн гэрээг 28 ААН-тэй,
- 2025 онд 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Болзошгүй үеийн материалын зардал” худалдан авах ажиллагаанд 182.0 сая төгрөгөөр 22 ААН, 2 иргэнтэй тус тус гэрээ байгуулсан байна.
- Мөн худалдан авах ажиллагааг түүвэрлэн үзэхэд шууд худалдан авах аргыг хэрэглэх зорилгоор 1 ААН-тэй 19.9 сая төгрөг, 10.9 сая төгрөг, 18.8 сая төгрөгөөр төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулан гэрээ шууд байгуулсан.

2.43 Дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 1,056.0 сая төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 35 дугаар зүйлийн 35.1³²-д заасантай нийцээгүй байна. Иймд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын зорилтыг хангахаар үр ашигтай, тооцоо судалгаатай, хэрэгжүүлэх хугацааг оновчтой төлөвлөж, төлөвлөлтийн дагуу тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулах, компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулахдаа төсөвт өртгийг хувааж гэрээ байгуулахгүй байх нь зүйтэй байна.

³¹ 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

³² 35.1.Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно

Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот арга хэмжээнд чиглээгүй, хандив, тусламж болон төсвийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

2.44 Төсвийн тухай хуульд³³ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутагт олгох хандив, тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт хамааруулсан бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргаатай гэрээ байгуулан ажиллахыг зөвшөөрсөн байна.

2.45 Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг MNS:ISO-26000:2012 стандарт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2025 оны А/350 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн хариуцлагын бодлого”, мөн орон нутгийн захиргаатай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ээр зохицуулж байна.

2.46 Дээрх бодлогын баримт бичиг болон гэрээний зохицуулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

2.47 Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2023–2025 онд нийт 58.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээс 10.0 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан, 8.4 тэрбум төгрөгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай шууд харилцан санхүүжүүлсэн байна. Зарцуулалтын төрлийг доорх хүснэгтээр багцлан харуулав.

Хүснэгт 11. Нийгмийн хариуцлагын 2023-2025 оны зардал, сая төгрөгөөр

№	Зарцуулалтын төрөл	Санхүүжсэн дүн
1	Засгийн газрын шийдвэртэй холбоотойгоор	3,069.4
2	Иргэд, аж ахуйн нэгжид шилжүүлсэн /Эко нойл, бэлчээрийн худаг .../	1,233.7
3	Эрүүл мэндийн чиглэлээр тусламж, дэмжлэг үзүүлсэн	3,845.0
4	“Оюутны тэтгэлэгт хөтөлбөр” санхүүжүүлсэн	240.0
5	“Орон нутгийн хөгжлийг дэмжих сан”-д шилжүүлсэн	10,000.0
6	Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр эвдрэлд орсон талбайд нийгмийн хариуцлагын хүрээнд дүйцүүлэн хамгаалалт хийсэн санхүүжилт	3,470.1
7	“Сая тонн-сая мод” хөтөлбөрийн үйл ажиллагаа, ойжуулалтын санхүүжилт	17,293.1
8	Нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон эрчим хүчний нүүрсний тусламж	19,641.4
Нийт дүн		58,792.7

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийгмийн хариуцлагын зардлын гүйцэтгэл

2.48 Компани нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн нийгмийн хариуцлагын хүрээнд гарах санхүүжилтийг хэрэгжүүлэх тохиолдолд тухайн арга хэмжээ нь дараах нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаатай шууд хамааралтай байх;
- Орон нутгийн нөлөөлөл, нөхөн зохицуулалт, дэд бүтцийн хэрэгцээнд чиглэсэн байх;
- Хуульд нийцсэн талуудын харилцан үүрэг бүхий гэрээгээр зохицуулагдсан байх;
- Компанийн үйл ажиллагааны хүрээнд бодит үр өгөөж, шаардлагатай, холбоотой байх зэрэг нөхцөлийг хангах шаардлагатай.

2.49 Дээрх шаардлагыг хангаагүй, нийтлэг нийгмийн арга хэмжээ, нэг удаагийн дэмжлэг, төсвийн шинжтэй санхүүжилт хэлбэрээр хэрэгжсэн тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хориглолтод хамаарахаар байна.

2.50 “Эрдэнэс Тавантолгой” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд “Сая тонн–Сая мод” хөтөлбөрийн ерөнхий бүсчилсэн төлөвлөгөөг боловсруулж 180 сая ширхэг модыг 4 зорилтын хүрээнд 2030 он хүртэл тарьж, ургуулахаар төлөвлөж “Хамтын ажиллагааны гэрээ”-г Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай 10 жилийн хугацаатай байгуулжээ. Үүнд:

³³ 60.2.Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.9.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж.

Хүснэгт 12. “Хамтын ажиллагааны гэрээ”-ний хүрээнд олгосон санхүүжилт, сая төгрөгөөр

Байгууллага	Гэрээний дүн	Нийт олгосон	Нийт зарцуулсан	Нийт буцаасан
БХЯ	18,802.5	15,150.8	8,161.3	7,166.3
Хөрөнгө	10,373.3	10,268.5	5,032.2	5,341.1
Үйл ажиллагаа	6,761.3	3,214.3	2,093.1	1,164.7
Ойжуулалт	1,668.0	1,668.0	1,036.0	660.5
ХХЕГ	26,450.1	18,976.1	16,560.6	5,889.5
Хөрөнгө	2,702.7	2,384.2	2,254.9	447.8
Үйл ажиллагаа	1,244.2	1,044.2	579.5	664.7
Ойжуулалт	22,503.2	15,547.7	13,726.1	4,777.0
ОБЕГ	28,045.8	27,500.0	27,500.0	-
Хөрөнгө	26,570.3	26,570.3	26,393.1	-
Үйл ажиллагаа	1,475.5	929.7	1,106.9	-
Ойжуулалт	-	-	-	-

Эх сурвалж: “Сая тонн–Сая мод” хөтөлбөрийн 2025 оны тайлан

2.51 Тус компани нь нийт 73.3 тэрбум төгрөгийн дүнтэй гэрээ байгуулснаас 61.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 52.2 тэрбум төгрөг зарцуулж, үлдэгдэл 13.1 тэрбум төгрөгийн буцаан олголтыг хийсэн байна.

2.52 Үүнээс үйл ажиллагаа болон ойжуулалтын хүрээнд гарсан нийт 17.3 тэрбум төгрөгийг нийгмийн хариуцлагын зардлаар тайлагнасан бөгөөд хөрөнгө оруулалтын 33.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Ойн газар”-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд нэг модны үнийг 2,689 төгрөгөөр тооцон, 13.9 сая мод тарихтай дүйцүүлэх саналын хамт “Ойн газар”-т хүргүүлсэн байна.

2.53 Хамтран ажиллах гэрээний дагуу санхүүжилт авсан төрийн цэргийн байгууллагуудаас Батлан хамгаалах яам 69.5 сая ширхэг мод тарихаар төлөвлөснөөс 1.9 сая ширхэг, Хил хамгаалах ерөнхий газар 30.9 сая ширхэг мод тарихаар төлөвлөснөөс 518.2 мянган ширхэг, нийт 2.4 сая ширхэг мод тарьсан байна.

2.54 Харин Онцгой байдлын ерөнхий газраас гэрээний хэрэгжилтийг удаа дараа шаардсан боловч “нууц” гэх үндэслэлээр хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ирүүлээгүй нь гэрээний үр дүн, санхүүжилтийн үр ашигт аудитын багийн үндэслэлтэй үнэлгээ өгөх боломжийг хязгаарлаж байна.

2.55 Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн санхүүжилтээр 586.0 мянган ширхэг мод тарьсан байна.

Хүснэгт 13. “Сая тонн – сая мод” хөтөлбөрийн ерөнхий бүсчилсэн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллага	Гэрээний дугаар	Гэрээний дүн /сая төгрөг/	Тарих мод /10 жил/	Тарьсан мод /3жил/	Гүйцэтгэлийн хувь	Ургасан мод /3 жил/	Ургалтын хувь	Нөхөн тарьсан мод
БХЯ	ЭТТ-2022/113	18,802.5	69,510,203	1,945,556	2.8%	315,180	16.2%	33,255
ХХЕГ	ЭТТ-2024/1002	26,450.1	30,855,600	518,200	1.7%	365,331	70.5%	95,936
ОБЕГ	ЭТТ-2022/503	28,045.8	68,354,500	-	-	-	-	-
Гэрээт/Г			4,014,667	439,965				
ЭТТ ХК			7,420,000	146,442				
Нийт			180,154,970	3,050,163	1.7%			129,191

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Сая тонн–Сая мод” хөтөлбөрийн 2025 оны тайлан


2.56 Гэрээний дагуу нийт 180.2 сая ширхэг мод тарихаар төлөвлөсөн ч 2025 оны байдлаар 3.0 сая ширхэг мод тарьсан байгаа нь олгосон санхүүжилттэй харьцуулахад мод тарих ажлын гүйцэтгэл хангалтгүй, тарьцын арчилгаа, ургалт, нөхөн тарилтын үр дүн, түүнчлэн санхүүжилтийн үр ашигт тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналыг сайжруулах шаардлагатай байна.

2.57 Олгосон санхүүжилттэй харьцуулахад мод тарих ажлын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь мод тарих ажлын хэрэгжилт, тарьцын арчилгаа, ургалт, нөхөн тарилтын үр дүн, түүнчлэн санхүүжилтийн үр ашигт тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналыг сайжруулах шаардлагатай тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Санхүүгийн тайлангийн шинжилгээнд үндэслэлгүй нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг тогтоож байгаа нь компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэхээр байна.

2.58 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор 2019, 2022, 2023, 2024, 2025 онуудын цэвэр ашгаас нэгж хувьцаанд 65.55 – 326.5 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:


Дүрслэл 8. Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол

2.59 Үндэсний аудитын газраас баталгаажуулсан 2019, 2022, 2023, 2024, 2025 онуудын санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлт дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл 9. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого болон цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний аудитын газрын баталгаажуулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайлан

2.60 Дээрх дүрслэлээс харахад 2019, 2022, 2023, 2024 онуудад тайлант үеийн цэвэр ашгийн борлуулалтын орлогод эзлэх хувь дунджаар 39 хувь байсан бол 2025 онд 19 хувь болж буурсан байна.

2.61 Энэ нь борлуулалтын өртөг өссөнтэй холбоотой бөгөөд үйл ажиллагааны зардлыг ангилал тус бүрээр борлуулалтын орлоготой харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 14. Тайлант үеийн зардлын төрлөөр борлуулалтын орлогод эзлэх хувь

Зардлын төрөл	2019 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Борлуулалтын өртөг	26%	20%	23%	19%	54%
Борлуулалт, маркетингийн зардал	13%	23%	23%	21%	22%
Ерөнхий ба удирдлагын зардал	1%	1%	2%	1%	2%

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын баталгаажуулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын багийн шинжилгээ

2.62 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019, 2022, 2023, 2024, 2025 онуудад цэвэр ашгийн 70-104 хувийг ногдол ашиг хэлбэрээр олгосон байна. Үүнд:

Дүрслэл 10. Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг, зарласан ногдол ашиг, төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний аудитын газрын баталгаажуулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын багийн шинжилгээ

2.63 Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1³⁴-д “ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;” 47.1.2-д “ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 30.5-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;”, 47.1.3-д “компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.” нөхцөлд ногдол ашиг хуваарилна гэж тус тус заасан байна.

2.64 Үндэсний аудитын газраас баталгаажуулсан 2019, 2022, 2023, 2024, 2025 онуудын санхүүгийн тайлангийн холбогдох үзүүлэлтээр ногдол ашиг хуваарилсны дараах төлбөрийн чадварын шинжилгээг хийхэд дараах байдалтай байна. Тухайлбал;

Хүснэгт 15. Ногдол ашиг хуваарилсны дараах төлбөрийн чадварын шинжилгээ он тус бүрээр

Төлбөрийн чадварын үзүүлэлт	Зохист түвшин	2019 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Эргэлтийн харьцаа	2	(0.13)	0.48	0.53	0.32	1.41
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	1-1.5	(0.51)	(0.35)	(0.35)	(0.27)	0.32

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын баталгаажуулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын багийн шинжилгээ

2.65 Дээрх үзүүлэлтээс харахад 2025 оны ногдол ашиг зарласны дараа төлбөрийн чадварын үзүүлэлтүүд өмнөх онуудтай харьцуулахад сайжирсан боловч зохистой түвшинд хүрээгүй байна.

2.66 Эргэлтийн харьцаа 2019 онд -0.13 байсан бол 2025 онд 1.41 болж өссөн нь богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадвар нэмэгдсэнийг харуулж байна. Мөн түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа өмнөх онуудын сөрөг үзүүлэлтээс 2025 онд 0.32 болж сайжирсан хэдий ч зохистой түвшин болох 1–1.5-аас доогуур хэвээр байна.

2.67 Иймд 2025 оны ногдол ашгийг олгосны дараа компанийн төлбөрийн чадвар тодорхой хэмжээнд сайжирсан боловч богино хугацаат өр төлбөрийг бүрэн хангах хэмжээнд хүрээгүй тул цаашид ногдол ашиг зарлахдаа Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Ногдол ашгийн журам”-ын 3.2-т заасан шаардлагыг тус тус хангах шаардлагатай байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг хуваарилах гэрээг хоёр тал дүгнээгүй, тараагдаагүй үлдэгдлийн шалтгааныг тодорхойлох талаар арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүй байна.

2.68 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019–2025 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдэд тараахаар “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай 7 удаагийн гэрээ байгуулж, аж ахуйн нэгжүүдэд 5.4 тэрбум төгрөг, иргэдэд 2,371.4 тэрбум төгрөг, нийтдээ 2,376.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна. Үүнд:

Дүрслэл 11. Иргэд, аж ахуй нэгжид хуваарилсан ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр

ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖИД ХУВААРИЛСАН НОГДОЛ АШГИЙН ДҮН

(сая төгрөгөөр)



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

³⁴ 47.1.Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

2.69 Дээрх гэрээнүүдийн хүрээнд хуваарилсан ногдол ашгаас хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжид 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2,219.0 тэрбум төгрөгийг олгож, 157.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараагдаагүй үлдсэн байна.

Хүснэгт 16. Ногдол ашиг хуваарилалтын нэгтгэл, дүн, сая төгрөгөөр /2026.05.22/

Он	Гэрээ	Бүртгэх өдөр	НА тараах	Тараасан ногдол ашиг		Тараагдаагүй үлдсэн НА	
				ХЭ-ийн тоо	Нийт дүн	ХЭ-ийн тоо	Нийт дүн
2019	2020.04.29	2020.04.02	Иргэн	2176113	155,120.1	336655	24,137.8
			ААН	298	483.7	188	88.6
2022	2024.01.31	2023.12.31	Иргэн	3214336	293,133.0	192720	17,511.4
			ААН	298	584.2	189	107.0
2023	2024.04.02	2023.12.31	Иргэн	3213135	716,897.9	194291	43,375.7
			ААН	298	1,428.4	190	263.0
2024-1	2024.12.20	2024.12.20	Иргэн	3190334	337,190.7	217092	22,924.8
			ААН	298	676.5	190	124.3
2024-2	2025.02.25	2024.12.31	Иргэн	3194295	277,922.1	213122	18,485.7
			ААН	298	556.8	190	102.3
			Хур.сан	594	53.5	0	0.0
			Хандив	-	0.0	10	0.7
2024-3	2025.04.04	2024.12.31	Иргэн	3191373	259,597.1	213141	17,281.6
			ААН	298	520.6	190	95.6
			Хур.сан	3432	289.1	0	0.0
			Хандив	-	0.0	75	5.3
2025	2026.04.29	2025.12.31	Иргэн	3166682	174,149.7	241339	13,319.6
			ААН	299	354.2	189	62.5
Нийт дүн					2,218,957.6		157,885.8

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (ХЭ-хувьцаа эзэмшигч, Хур.сан-Хуримтлалын сан)

2.70 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны ногдол ашиг хуваарилалт 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 241339 хувьцаа эзэмшигчийн 13.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараагдаагүй байна. Үүнээс 132692 (55 хувь) нь нас барсан, 88565 (36 хувь) нь одоо байгаа ч тодорхойгүй, 13823 (6 хувь) нь харьяатаас гарсан, 6259 (3 хувь) нь хүчингүй регистрийн дугаараар бүртгэлтэй байгаа нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн төлөвөөс шууд хамааралтай байна.

Хүснэгт 17. Хувьцаа эзэмшигчдийн тараагдаагүй ногдол ашгийн бүртгэлийн төлөв

Тараагдаагүй НА-н төлөв	2019 он	2022 он	2023 он	2024 он-1	2024 он-2	2024 он-3	2025 он
Хүчингүй регистртэй	-	6145	6149	6271	6272	6272	6259
Нас барсан	-	108126	108222	119827	121826	121826	132692
Одоо байгаа, тодорхойгүй	-	64833	66279	77181	71211	71295	88565
Харьяатаас гарсан	-	13616	13641	13813	13823	13823	13823
Нийт	336655	192720	194291	217092	213122	213141	241339

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (НА-ногдол ашиг)

2.71 “Эрдэнэс Тавантолгой” ХК 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшүүлж эхлэхээс өмнө Монгол Улсын харьяатаас гарсан буюу хувьцаа эзэмших боломжгүй 1577 иргэнд хувьцаа эзэмшүүлснээс 96 иргэний харьяатаас гарсан огноо тодорхойгүй байна.

2.72 Мөн нас барснаар бүртгэгдэж, гэрчилгээ олгосон буюу хувьцаа эзэмших боломжгүй 410 иргэнд хувьцаа эзэмшүүлснээс 22 иргэний нас барсан огноо тодорхойгүй, 8 иргэн нь хувьцааны үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 18. Хувьцаа анх эзэмшүүлэхээс өмнө нас барсан болон харьяатаас гарсан иргэдийн мэдээлэл, ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр

	Хувьцаа эзэмших боломжгүй иргэдийн тоо	Анх хувьцаа эзэмшсэн иргэдэд хуваарилсан НА			Хувьцаа эзэмших боломжгүй иргэдэд олгосон НА		
		ХЭ	Хув/тоо	Дүн	ХЭ	Хув/тоо	Дүн
Нас барсан	402	393	425199	322.8	9	9326	1.0
Харьяатаас гарсан	1577	1563	1685760	1,298.7	14	13934	1.1
Нийт дүн			2110959	1,621.5		23260	2.1

Эх сурвалж: Аудитын баг (ХЭ-хувьцаа эзэмшигч, НА-ногдол ашиг)

2.73 Дээрх иргэдэд 2019 оноос хойш 7 удаагийн ногдол ашиг хуваарилалтаар нас барсан 393 иргэний 425.2 мянган ширхэг хувьцаанд ногдох 322.8 сая төгрөг, Монгол Улсын

харьяатаас гарсан 1577 иргэний 1.7 сая ширхэг хувьцаанд ногдох 1,298.7 сая төгрөг, тараагдаагүй ногдол ашгийн дансанд нийт 1,621.5 сая төгрөг хуримтлагдсан байна.

2.74 Түүнчлэн хувьцаа эзэмшүүлэхээс өмнө нас барсан 9 иргэнд нийт 1.0 сая төгрөгийн ногдол ашиг олгосон бөгөөд үүнээс 1 иргэнд 2019 оны ногдол ашгаас 60.8 мянган төгрөг, 1 иргэнд 2022 оны ногдол ашгаас 104.9 мянган төгрөг, 7 иргэнд 2024 оны эхний хуваарилалтаар 850.5 мянган төгрөг, мөн Монгол Улсын харьяатаас гарсан 14 иргэнд 2019 оны ногдол ашгаас 1.1 сая төгрөг, нийт 23 иргэний 2.1 сая төгрөгийн зөрчилд “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай гэрээ дүгнэж, тооцоо нийлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

2.75 Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд хүчингүй регистрийн дугаартай 6272 иргэний хийсвэр бүртгэлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшүүлж, ногдол ашиг хуваарилсан байна. Үүнээс регистрийн дугаар шинэчлэгдсэн 2498 иргэнээс 2019 онд 67 иргэн, 2022 онд 48 иргэн, 2023 онд 48 иргэн, 2024 онд 49 иргэн, 2025 онд 49 иргэнд тус тус холбогдох нийт 41.7 сая төгрөгийн ногдол ашгийг хүчинтэй регистрийн дугаарт шилжүүлэн бүртгэх шаардлагатай байна.

Хүснэгт 19. Ногдол ашгийг хүчингүй регистрийн дугаараар хуваарилсан хувьцаа эзэмшигчийн тоо, ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр

Он	Хүчинтэй РД-аар шилжүүлэн бүртгэх НА		Хүчингүй бүртгэлээр хуваарилсан үлдэгдлээс суутгах НА		Хүчингүй бүртгэлээр хуваарилсан нийт НА	
	ХЭ	Дүн	ХЭ	Дүн	ХЭ	Дүн
2019	67	5.8	5828	505.9	5895	511.7
2022	48	5.0	6097	639.2	6145	644.3
2023	48	12.3	6101	1,565.3	6149	1,577.6
2024-1	49	6.0	6222	755.7	6271	761.6
2024-2	49	4.9	6223	622.1	6272	627.0
2024-3	49	4.6	6223	581.6	6272	586.2
2025	49	3.1	6220	393.2	6269	396.3
Нийт дүн		41.7		5,063.0		5,104.7

Эх сурвалж: Аудитын баг (ХЭ- хувьцаа эзэмшигч, НА-ногдол ашиг)

2.76 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2019-2025 оны ногдол ашиг хуваарилалтаар хийсвэр буюу хүчингүй бүртгэлд нийт 5.1 тэрбум төгрөг хуваарилснаас 5.0 тэрбум төгрөгийн ногдол ашиг хадгалалтанд үлдсэн байна.

Хүснэгт 20. Ногдол ашгийг хүчингүй бүртгэлээр давхардуулан олгосон хувьцаа эзэмшигчийн тоо, ногдол ашгийн дүн, сая төгрөгөөр

Он	Хүчинтэй РД-аар шилжүүлэн бүртгэх НА		Хүчинтэй, хүчингүй бүртгэлээр олгосон НА		Хуваарилсан үлдэгдлээс суутгах НА		Бүртгэл давхардуулан олгосон нийт НА	
	ХЭ	Дүн	ХЭ	Дүн	ХЭ	Дүн	ХЭ	Дүн
2019	196	17.0	39	3.3	50	4.3	285	24.7
2022	23	2.4	-	-	104	10.8	127	13.2
2023	25	6.4	-	-	98	24.9	123	31.3
2024-1	-	-	1	0.1	-	-	1	0.1
2025	-	-	3	0.2	-	-	3	0.2
Нийт дүн		25.8		3.6		40.0		69.5

Эх сурвалж: Аудитын баг (ХЭ-хувьцаа эзэмшигч, НА-ногдол ашиг)

2.77 Дээрх хүснэгтээс үзэхэд 2019-2023 оны ногдол ашгийг хүчингүй бүртгэлээр хуваарилсан 25.8 сая төгрөгийн ногдол ашгийг хүчинтэй регистрийн дугаараар шилжүүлэн бүртгэх, мөн хүчинтэй, хүчингүй бүртгэлээр ногдол ашиг давхардуулан олгосон 3.6 сая төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай гэрээ дүгнэж, тооцоо нийлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

2.78 Мөн хүчинтэй, хүчингүй регистрээр давхардуулан ногдол ашиг хуваарилсан тараагдаагүй үлдэгдлээс хүчингүй бүртгэлийн 40.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

2.79 Дээрх зөрчлүүд нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн мэдээллийг Улсын бүртгэлийн мэдээлэлтэй тухай бүр тулган баталгаажуулж, шинэчлээгүй мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний

хэрэгжилтийг дүгнэж, гүйцэтгэлийг баталгаажуулах акт үйлдээгүйгээс үүссэн бөгөөд ногдол ашиг хуваарилалтын болон бүртгэл хяналтын тогтолцоо хангалтгүй байгааг харуулж байна.

2.80 “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд хуримтлагдсан тараагдаагүй үлдэгдлийг хянаж үзээд ногдол ашгийн хуваарилалттай холбоотой илэрсэн нийт 6.7 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.81 Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн хоёр³⁵ дахь хэсэгт /2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр/ орсон нэмэлт өөрчлөлтөөр төр байгалийн баялаг ашиглах урт хугацааны бодлоготой байх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангаж, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахад иргэдэд өгөөжийг хүртээх зорилго бүхий “Үндэсний баялгийн сан”-тай болох, бие даасан хуультай болохоор зохицуулсан байна.

2.82 Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталж, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Дүрслэл 12. Ирээдүйн өв сан болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн зохицуулалт

**Ирээдүйн өв сангийн тухай
хууль/2016.02.05/**

7.1. Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
7.1.1. Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг
/2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаас өмнөх зохицуулалт/

**Үндэсний баялгийн сангийн
тухай хууль/2024.04.19/**

11.1. Хуримтлалын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 11.1.2.6. Энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ногдол ашгийг

2.83 Ирээдүйн өв сангийн тухай хууль болон Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд мөн тул төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг Ирээдүйн өв сан болон Хуримтлалын санд төвлөрүүлэхээр байна.

2.84 “Эрдэнэс Тавантолгой” ХК 2019-2025 оны цэвэр ашгаас төрийн эзэмшлийн хувьцаанд нийт 7,643.4 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан ба Ирээдүйн өв сан болон Хуримтлалын санд дараах ногдол ашгийг төвлөрүүлэхээр тооцоолсон байна. Үүнд:

Хүснэгт 20. Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашиг, тэрбум төгрөгөөр

Он	Төрийн эзэмшлийн хувьцаанд хуваарилсан ногдол ашиг	Үүнээс санд төвлөрүүлэх хөрөнгө		Эрдэнэс Монгол ХХК-д олгох ногдол ашиг
		Ирээдүйн өв сан	Хуримтлалын сан	
2019 он	880.2	880.2	-	-
2022 он	958.9	958.9	-	-
2023 он	2,346.3	2,346.3	-	-
2024 он	2,879.8	-	979.1	1,900.7
2025 он	578.2	-	196.6	381.6
Нийт дүн	7,643.4	4,185.4	1,175.7	2,282.3

Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” ХК

³⁵ 6.2. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

2.85 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2019 оны цэвэр ашгаас Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 880.2 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлээгүй бөгөөд Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолын дагуу уг хөрөнгөнөөс “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 117.2 тэрбум төгрөгийн зээлийн төлбөрт тооцон Монгол Улсын Хөгжлийн банканд шилжүүлсэн асуудлыг Үндэсний аудитын газрын 2023 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар³⁶ хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж байна.

2.86 Харин Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар, Засгийн газрын 2024 оны 46 дугаар тогтоолуудыг үндэслэн 2022, 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хуваарилах асуудлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01, 02 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн байна.

2.87 Дээрх тогтоолын дагуу 2022 оны 958.9 тэрбум төгрөг, 2023 оны 2,346.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасны дагуу төвлөрүүлээгүй, өр төлбөрөөр бүртгэсэн байна.

2.88 Түүнчлэн Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас төрийн эзэмшлийн хувьцааны 34 хувьд ногдох 979.1 тэрбум төгрөгөөс 2024-2025 онд 595.4 тэрбум төгрөгийг, аудитын явцад 100.0 тэрбум төгрөг шилжүүлж, үлдэгдэл 283.7 тэрбум төгрөг болон 2025 оны цэвэр ашгаас 196.6 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд тус тус төвлөрүүлээгүй байна.

2.89 Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг³⁷, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1³⁸ дэх хэсэг /2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаас өмнөх зохицуулалт/, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.6³⁹ дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн байна.

³⁶ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2022 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

³⁷ 6.2. “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”,

³⁸ 7.1.1. “Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг”

³⁹ 11.1.2.6 “энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн 34 хувьд ногдох ногдол ашгийг”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох 2019, 2022, 2023 оны ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхгүйгээр өр, авлагад суутган тооцох шийдвэр гаргасан байна.
2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг энгийн хэлбэрт шилжүүлэх, нээлттэй болгох эрх зүйн орчин бүрдсэн, бэлтгэл ажил хийгдэж байна.
3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас “Тавантолгой түлш” ХХК-д 2018 оноос хойш олгосон нийт 1,761.0 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн гэрээнд хяналт тавьж ажиллаагүйгээс эргэн төлөлт хийгдээгүй, гэрээний эрх үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.
4. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК хооронд байгуулсан менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг дүгнэдэггүй, үр дүнгээс үл хамааран борлуулалтын орлогоос тооцож урьдчилан олгодог ба 2023-2025 оны хооронд нийт 206.1 тэрбум төгрөгийг менежментийн төлбөрт шилжүүлсэн байна.
5. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тогтворгүй, хууль тогтоомжийг мөрдөөгүй, гүйцэтгэл дунджаар 30-40 хувьтай, худалдан авах үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
6. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 2023-2025 онд 58.8 тэрбум төгрөг зарцуулснаас 8.4 тэрбум төгрөгийг нь хандив, тусламж болон төсвийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан байна.
7. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг тодорхойлохдоо эдийн засгийн бодит тооцоололд үндэслэлгүй, төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгчээс ирүүлж буй удирдамжийн дагуу тогтоож байгаа нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.
8. “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК хооронд байгуулсан ногдол ашиг хуваарилах гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн бодитой байдал алдагдсан, хувьцаа эзэмших боломжгүй иргэдэд хувьцаа эзэмшүүлж, түүнчлэн ногдол ашиг хуваарилж олгосон байна.
9. Хууль, журмын шаардлага хангаагүй болон хувьцаа эзэмшүүлэхээс өмнө нас барсан, харьяатаас гарсан, хийсвэр болон хүчингүй бүртгэлтэй иргэдэд нийт 6.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.
10. Төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ашгаас Ирээдүй өв санд 3,305.2 тэрбум, Хуримтлалын санд 480.3 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлээгүй, өр төлбөрөөр бүртгэсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ:

1. Төрийн мэдээллийн нэгдсэн сан дахь хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэл, хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногдол ашигтай холбоотой шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх.

"ЧИНГИС ХААН БАЯЛГИЙН САН НЭГДЭЛ" ХХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. Төрийн өмчийн эзэшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн хуримтлагдсан өр төлбөрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хамаарал бүхий аж ахуйн нэгжид олгосон санхүүжилтийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, компанийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах,
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хууль, журмыг мөрдөж ажиллах,
3. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, санхүүгийн тайлангийн шинжилгээнд үндэслэн тодорхойлж, "Чингис хаан баялгийн сан нэгдэл" ХХК-д хүргүүлж байх.

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ийн гүйцэтгэх захиралд:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн нэгдсэн бүртгэлийг хөтлөхдөө харьяатаас гарсан болон нас барсан хугацаа тодорхойгүй, хүчингүй регистрийн дугаартай иргэдийн бүртгэлийг иргэний бүртгэлийн мэдээллийн сантай тулган баталгаажуулж, хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах арга хэмжээг Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран хэрэгжүүлэх.

[illegible]

[illegible]